

МОНГОЛЫН ОРОС СУДЛАЛД ТУЛГАРЧ БУЙ АСУУДЛУУД

О.БАТСАЙХАН

*Түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D)
ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн
Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан*

Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд “Туравдагч хөрш” хэмээх шинэ нэр томъёо оруулж, гадаад бодлогодоо ихээхэн өөрчлөлт оруулахыг хичээж байгаа билээ. Тус үзэл баримтлалд: “ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд аль нэгийг нь өрөөсгөлөөр дагахгүй, бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хамтын ажиллагаа хөгжүүлнэ. Чингэхдээ энэ хоёр оронтой харилцаж ирсэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзана” хэмээн заасан билээ. Хэдийгээр даяаршиж буй дэлхийд оршиж буй ч шууд хиллэсэн хөрш Орос, Хятад хоёр оронд гарч буй томоохон өөрчлөлт нь Монгол Улсын гадаад орчинд шууд нөлөөлж байна.

Өөрөөр хэлбэл, Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал эл хоёр орноос шууд хамааралтайгаар оршиж ирсэн тул цаашид ч эл хоёр улсын харилцаа хамаарал дээр Монгол Улс орших нь хэн бүхэнд ойлгомжтой. Иймээс бид удаа дараа гадаад бодлогын үзэл баримтлалдаа ийнхүү тунхаглан зарлаж, хоёр хөрштэйгээ эв найрамдалтайгаар эн тэнцүү харьцахыг чухалчилдаг билээ. Чухамдаа Монгол Улсын гадаад төдийгүй дотоод бодлогод хоёр орны хөгжил, бодлого, үйл ажиллагаа онцгой байр эзэлж буй тул 1911 онд сэргээн тунхагласан Монгол Улсын гадаад яаманд умард болон өмнөд хөршийн хэлтэс байгуулан эл хоёр орны талаар бүр тэр үеэс эхлэн үргэлж судалгаа явуулж, өөрийн бодлогоо тодорхойлж ирсэн уламжлалтай билээ.

Энэхүү уламжлалын нэг хэсэг бол эдүгээ ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн бөгөөд өмнө нь Дорно дахин судлалын хүрээлэн нэртэй байв. Ер нь Орос, Хятадын баримтлах бодлогоос бидний алс хэтийн бүү хэл өнөө маргаашийн хувь заяа хамаарч байгаа нь нууц биш. XX зууны социализмын ид оргил үед Монголын эдийн засгийн 80 гаруй хувь нь хойд хөршөөс хамаарч байсан бол өнөөдөр өмнөд хөршөөсөө бараг төдий чинээ хувь хамааралтай болж байна.

Монгол дахь Оросын эрх ашиг, Хятадын эрх ашиг, аливаа гадаадын эрх ашиг ямар байхыг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоож чадаагүй шахам байна. Шуудхан хэлбэл, орос, хятад судлалаар Монголд улс төр, эдийн засгийн бие даасан судалгааны хүрээлэн байх нь стратегийн онц ач холбогдолтой юм. Үнэндээ

“мөнхийн дайсан, мөнхийн нөхөр гэж үгүй, харин мөнхийн эрх ашиг буй” гэдэг бус уу. Дээр нь үнэндээ бид “нүүгээд явдаггүй” л юм бол Орос, Хятад хоёр улс Монгол Улсын мөнхийн хөрш байх болно.

Эл үүднээс авч үзвэл монголчуудад уламжлалаа ч, өнөөгөө ч бодсон Орос, Хятадын талаар нарийн ажиглалт, гүнзгий судалгаа байнга хийж, засаг төрийн бодлогодоо анхаарч байх нь чухал хэмээн үзэж байна. Монголын төр судалгаа шинжилгээгүйгээр, шинжлэх ухааны үндэслэлгүйгээр гадаад, дотоод бодлогоо тодорхойлж явах нь утгаа хад мөргөхтэй агаар нэгэн болно.

ОХУ-ын хүчин зүйл

Олон арван жилийн найрсаг харилцааны баялаг түүхтэй манай хоёр орон, ард түмнийг өнөөдөр ардчилал, шинэчлэлийн олон төрлийн ижил төстэй зорилтууд, харилцан шүтэлцээтэй хамтын ажиллагааны ашиг сонирхол холбож буй. Манай орны ойрын 5-10 жилийн хөгжилд ОХУ-тай тогтоосон эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухаан, соёлын салбарын хамтын ажиллагааны үүрэг роль улам өсөн нэмэгдэх боломж их байна. Ялангуяа Орос, Монголын хил орчмын бүс нутаг, субъектүүд хоорондын хэлхээ холбоо, харилцан ажиллагааг бүхий л талаар өргөжүүлэн хөгжүүлэх зорилт маш чухал болж байна. Энэ нь хоёр орны харилцааны өнөөгийн болон цаашдын шинж төрхийг тодорхойлох гол хүчин зүйл мөн.

Бүс нутгийн харилцаа бол улс төрийн гэхээсээ эдийн засаг, соёл иргэншлийн үнэт зүйлд илүү тулгуурласан, бие биеэс нь салгаж болшгүй бодит шүтэлцээ, харилцан хамаарлыг шингээн илэрхийлж, хүмүүнлэгийн хүчин зүйлд шууд чиглэсэн тасралтгүй үргэлжилсэн хөдөлгөөнт чанарыг агуулж байдгаараа хөрш орнуудын хөгжлийн чухал зүй тогтолт үйл явц мөн. Энэхүү бодит зүй тогтлыг танин мэдэж, мөн чанарыг нь нээхийн хэрээр, шилж сонгодоггүй, салгаж болдоггүй хөршүүдийн хамтын ажиллагааг зах зээлийн харилцааны шинэ нөхцөлд нийцүүлэн бие биедээ оршихуй, хөгжихүйн хүчин зүйл болж байх бодит агуулгын түвшинд нь хүртэл идэвхжүүлж өргөжүүлэх шаардлага буй нь тодорхой.

Монгол, Орос хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа орчин цагт стратегийн түншлэлийн замналд орсонтой холбогдуулан уг чиглэлийн судалгаа улам их эрчимжих шаардлага урган гарч байна. Өнөөгийн байдлаар уг судалгааг бүрэн утгаар нь ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Орос судлалын салбар явуулахыг хичээж байна. Учир нь уг салбарын эрдэмтэн судлаачид бүгд эрдмийн зэрэг цолтой, ихэнх нь Орост боловсрол эзэмшсэн бөгөөд уг чиглэлээр олон жил дагнан ажиллаж байгаа. Түүнчлэн уг салбарын явуулж буй үйл ажиллагаа, судалгаа нь тухайн улсын гадаад, дотоод бодлого, эдийн засаг, хоёр орны худалдааны хамтын ажиллагаа зэрэг чухал чиглэлийг байнга хамарч ирсэн билээ. Тухайлбал манай хоёр орны харилцааны гол чиглэл бол бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагаа бөгөөд энэ тал дээр иж бүрэн судалгаа хийж олон тооны бүтээл гаргаж нийтэлсэн, мөн сүүлийн үеийн шаардлагад нийцүүлэн судалгааг эдийн

засагжуулах талыг баримталж энэ талын судалгаанд анхаарал хандуулан ажиллаж байна. Үүнд уул уурхайн салбар, дэд бүтцийн асуудал, түлш эрчим хүч, төмөр зам гэх мэт асуудлууд судалгааны ихэнх хувийг эзэлж буй. Мөн үндэсний аюулгүй байдлын асуудал сүүлийн үед олны анхаарлыг татаж байгаатай холбогдуулан энэ талын судалгаа, чиглэлийг баримтлан ажиллаж байна.

Одоогийн байдлаар тус хүрээлэнгээс гадна ҮАБЗ-ийн дэргэдэх Стратеги судлалын хүрээлэн дээр Орос судлалын салбар байдаг хэдий ч байгуулагдаад төдийлөн удаагүй бөгөөд улс төрийн судалгаа хийдэг цөөн хүний бүрэлдэхүүнтэй, иймээс манай хүрээлэнгийн Орос судлалын салбар судалгааны төвийн хэмжээнд хүрсэн цорын ганц цогц төв гэсэн утгаар Монгол Улсын гадаад бодлогод Орос судлалыг цаашид өргөжүүлэн судлахад томоохон үүрэг гүйцэтгэх нь дамжиггүй.

Манай хүрээлэнгийн зүгээс Орос, Хятад судлалыг өргөжүүлэн, түүхэн замнал хийгээд орчин цагийн шаардлагад тулгуурлан энэ хоёр орны судалгааг голлож байгаа билээ. Бид олон тооны эрдэм шинжилгээний бага хурал, олон улсын хурал, форум зэргийг амжилттай зохион байгуулж, Монгол Улсын гадаад бодлого хийгээд шинжлэх ухаанд үнэтэй хувь нэмэр болохуйц ном товхимол, бүтээл зэргийг гаргаад байна.

Социализмын үед Зөвлөлт судлал гэж байсангүй, харин Орос хэлний танхим байлаа. Орос хэлний багш нар, Монгол-Зөвлөлтийн харилцааны талаарх судалгаа мөн байв. Монголын түүхийн судлал дотор Монгол-Зөвлөлтийн судалгаа заавал хамаарч ирлээ. 1920-иод оноос Зөвлөлт Холбоот улстай илүү харилцаатай байсан боловч Монголд Зөвлөлт судлалын төв байгаагүй. Монгол-Зөвлөлтийн харилцааны түүх, МАХН-ЗХУКН харилцааны түүхээр гарсан ном товхимол бий юм.

1990 оноос хойш бидний чиг баримжаа өөрчлөгдсөн тул Орос судлал өмнө явж ирсэн байдлаар явах боломжгүй болсон юм. Үүнтэй холбоотойгоор Орос судлал гэж юу болохыг нарийвчлан тогтоогүйн улмаас хоёр орны харилцааны асуудлыг голцуу хамруулж ирлээ. Цаашид Орос орон судлал, Орос орны дотоод, гадаад бодлого, стратегийн асуудлыг тодорхой нарийвчлан дагнан судалдаг байх нь илүү зохимжтой юм. Энэ нь Монгол Улсын гадаад бодлого боловсруулах үндэслэл болох учиртай гэж бодно. Хоёр орны харилцааны асуудал Орос судлалын нэг хэсэг мөн хэдий ч Орос орон судлалыг илүү гүнзгийрүүлэх шаардлага бол бодитой оршсоор байгаа юм.

Үүнд хүний хүчин зүйлээс гадна төрөөс чиглүүлсэн уялдаатай бодлого байх хэрэгтэй юм. Харин Орос судлал нь ОХУ-ын соёлын сурталчилгааны нэг хэсэг болоод яваад байж болохгүй. Мөн Гадаад харилцааны яамны Оросын бодлогыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар хамтрах нь зүй боловч өөрсдийн үндсэн ажил болгож болохгүй буюу Гадаад харилцааны яамны хавсарга шиг болж болохгүй юм.

Одоо байгаа Орос судлалын салбар Гадаад орнуудын орос судлалын төвүүдийн жагсаалтад багтдаггүй. Манай Орос судлал сайн дурын шинжтэй чиглэлээр судалгаа явуулж ирсэн байна. Угтаа гадаад бодлогын үзэл баримтлалд заасны дагуу судалгааны чиглэлээр Орос судлалыг хөгжүүлж, Монгол Улсаас Орос Улсын

талаар баримтлах төрийн бодлогын шинжлэх ухааны үндэслэл болох учиртай.

Өөрөөр хэлбэл, Орос орон судлалыг бие даалгах буюу түүх, улс төр, эдийн засаг, соёл, хэл судлал чиглэлүүдийг цогцоор авч явуулах шаардлага зүй ёсоор оршиж байна. Энэ том хөрш Орос орныг судлахад хүч тарамдах, дагнан судалгаа эрхлэх явдал дутмаг байгааг хэлэх нь зөв байх. Тиймээс Орос судлалаар судлаач бэлтгэх шаардлагатай байна.